

Уулбаян сумын Засаг даргын Тамгын газрын
2022 оны 02 дугаар сарын үйл ажиллагааны тайлан

2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр

Төрийн удирдлагын чиглэлээр:

Хоёрдугаар сард 30 албан бичиг бүртгэгдсэн байна. Үүнээс хариутай албан бичиг 10 ирсэн бөгөөд холбогдох албан тушаалтанд хүргүүлж, биелэлтийг ханган ажиллаж байна. Ирсэн захирамж, тогтоол-12, удирдлагын баримт бичгийн хувьд сумын Засаг даргын “А” захирамж – 10 батлагдсан бөгөөд хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Нийт ирүүлсэн өргөдөл 6 (ажлын байр хүссэн-6) байна.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:

2022 оны 01 сарын 03-наас бүртгэлийн нотлох баримтуудыг цахимжуулж эхэлсэн. Одоогийн байдлаар 18 бүртгэл 51 нотлох баримтыг цахимжуулсан.

2022 оны 02 дугаар сарын байдлаар төрсний бүртгэл -5 / эм -4, эр-1/, нас барсны бүртгэл -2 /эр-2/, гэрлэсний бүртгэл -2, иргэний үнэмлэх шинээр /16 нас/ - 7 / эр -2, эм-5/, иргэний үнэмлэхний сунгалт 25,45 нас – 8 /эр-3, эм-5/, шилжин ирсэн -3 /эр-2/, лавлагаа -13, төрсний гэрчилгээ дахин олголт -2 тус тус бүртгэгдсэн.

Төсөв санхүүгийн талаар

Улсын болон орон нутгийн төсвийн байгууллагуудын харилцах, няравын тайланг үдэж цэгцлэн 2021 оны төсвийн байгууллагуудын санхүүгийн жилийн эцсийн тайланг гаргаж Төрийн аудитын байгууллагад шалгуулаж Төрийн өмчийн байгууллагад үндсэн хөрөнгийг нэр төрөл бүрээр тулгах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Төрийн байгууллагуудын 2-р сарын санхүүжилтийг олгож цалин, НДШ-ийг бүрэн хийж гүйцэтгэлээ. Төсвийн постороо хийж 2021 оны ОНХС-ийн тайланг Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.

ААНБ-ийн санхүүгийн тайланг хийж гүйцэтгэсэн. 2022 онд нийлүүлэх статистикийн бүтээгдхүүн нийлүүлэх график төлөвлөгөөг гаргаж мэдээг мэргэжилтэнгүүдэд хариуцуулж өглөө.

Газар зохион байгуулалтын чиглэлээр:

1997 оноос 2008 оны хооронд газар өмчлөх, эзэмших, ашигла эрхийн гэрчилгээ авсан иргэдийг газрын цахим системд бүртгэгдсэн эсэх судалгааг гарган нийт нэгж талбарын тоог аймгийн мэргэжилтэнд өгсөн. Захирамж гарсан хэрнээ газраа аваагүй 18 иргэний судалгааг гаргаж улсын бүртгэлээс гэрчилгээ авсан үгүйг тулгасан.

Иргэд өөрсдөө egazar.gov.mn сайтаар орон газартай холбоотой мэдээллээ шалгах талаарх зарыг сумын цахим хаягуудаар иргэдэд түгээн ажиллав

Аймгийн төлбөрийн мэргэжилтний боловсруулсан санал, асуумжийг сумын веб сайт болон цахим хуудсанд байршуулж санал авах ажилд хамтран ажилласан.

2-р сарын 9-ны өдрийн 11 цаг гээд орлогч дарга - Х.Баттөр, 1-р багийн засаг дарга – Г.Гэрэлболд, Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн – Т.Ренчин, 1-р багийн иргэн Т.Чулуунбаатар нарын хамт 1-р багийн хилийн цэсийн тодруулалтын ажлаар яван сумын урд цэгээс хойд цэг хүртэл нийт 11 эргэлтийн цэг дээр очин GPS-р цэгүүдийг олон тодруулан ойр байрлах айл өрхүүдэд бусад сумтай хиллэдэг газруудыг сурталчилан ажиллсан.

Шинээр үүссэн ламтны гудамжны хаягийг Гангачуулган ХХК-аар гүйцэтгүүлж, 2022.02.15-ны өдөр газар дээр нь суурилуулав.

Байгаль орчны чиглэлээр:

Усны чиглэлээр:

Цөлжилт газрын доройтлыг бууруулах зорилшоор 2020 онд Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Зүүнбулгийн эхийг хашиж хамгаалж нөхөн сэргээх ажлыг Хөдөө аж ахуйн их сургуулийн Аргэкологийн баг бүрэлдэхүүн гүйцэтгэж үр дүнг орон нутаг хүлээн авсан. Иймд цаашид эд хөрөнгө бүрэн бүтэн байдлыг хариуцах байгууллагыг тодорхойлох зорилгоор Иргэдийн тэргүүлэгчдийн ээлжит 6 дугаар хуралдаанаар оруулан батлуулж хариуцах байгууллагыг Засаг даргын Тамгын газарт харицуулахаар баталсан.

Уул уурхайн чиглэлээр:

Сумын нутаг дэвсгэрийг хамгаалах, сөрөг үйл ажиллагаа явуулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Зарим газар нутгийг тусгай хамгаалалтад авах тухай” саналыг иргэдийн төлөөлөгчдийн хурлаар оруулан батлуулж Ашигт малтмал газрын тосны газарт хүргүүлсэн. Тус тогтоолын хариу Ашигт малтмалын тухай хуулийн 14.2 дох заалтыг хангахгүй байна гэсэн хариу ирүүлсэн. Үүний дагуу нягтлан үзэж тус тогтоолыг Иргэдийн төлөөлөгчдийн ээлжит 6 дугаар хуралдаанаар оруулан батлуулж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн.

Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журмыг багийн дарга нарт таниулав. Журам мөрдөгдөж эхлэхтэй холбогдуулан бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулах талаар судалгаа хийж зохих мэргэжилтэнтэй хамтран ажиллаж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн санал асуулганд “Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” батлуулах гэсэн санал оруулав.

Малчдын зөвлөгөөн зохион байгуулахтай холбогдуулан захирамж, хөтөлбөр бэлтгэн Засаг даргын тамгийн газрын даргаар хянуулав.

Хүнс, худалдаа, үйлчилгээ чиглэлээр:

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний бодит нөөцийн судалгаа

Бүтээгдэхүүний нэр	Нөөц
Гурил	22 тн
Гурилан бүтээгдэхүүн	420 ш
Будаа	720 кг
Хуурай/Шингэн сүү	160 ш
Өндөг	1190 ш
Ургамлын тос	307 ш
Төмс	200 кг
Хүнсний ногоо	100 кг
Элсэн чихэр	600 кг
Давс	230 кг
Савласан ус	250 ш

Хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний нөөц болон татан авалтын хомсдол үүсээгүй, тээвэрлэлт хэвийн явагдаж байна.

Хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалтын горим, түргэн гэмтэж чанар байдлаа алдах, хүнсний бүтээгдэхүүнийг техникийн зохицуулалтад заагдсан горимд хадгалж байгаад хяналт тавин хоол хүнсээр, дамжих өвчин, хордлого, халдвараас урьдчилан сэргийлэх, зорилгоор мэргэжлийн байгууллагаас гаргасан зөвлөмж, зөвлөгөөг тогтмол хүргэн ажиллаж байна.

Шатахуун түлшний үнэ нөөц 2022 оны 1 сарын 18-ны байдлаар

№	Байгууллагын нэр	A-80	A-92	ДЗ
1	“Байшинт Ойл” ХХК	8.2 тн	12.7тн	3 тн
2	Үнэ	2450төг	2500төг	3040 төг

№	Байгууллагын нэр	A-80	A-92	ДЗ
1	“Арвижих Дарь” ХХК	4.5тн	14тн	5тн
2	Үнэ	2470 төг	2540 төг	3040 төг

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн судалгааг 1-2 сартай харьцуулан харуулав.

№	Бүтээгдэхүүний нэр	2022 оны 1 сарын 20 байдлаар	2022 оны 2 сарын 24 ны байдлаар
---	--------------------	---------------------------------	------------------------------------

1	гурил	Дорнод дээд	36000	36000
		УБ 1-р зэрэг	37000	38500
		Өөг	34000	34000
2	Цагаан будаа		3000-3500	3000-3500
3	Шингэн сүү		3700	3800
4	Хуурай сүү		6500-12500	6500-12500
5	Элсэн чихэр		3000-3500	3500
6	Ургамлын тос		5800-6500	5800-6500
7	Өндөг		650-700	600
8	Төмс		1300-1500	1500
9	Хүнсний ногоо	Сонгино	3000	2800-3500
		Байцаа	2500-3000	3000
		Лууван	2200	3500
		Сармис	2500	3000
10	Давс		1000-1500	1000-2800
11	Савласан ус		800-3500	1600-4500

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний зохиомол үнийн хомсдол үүсээгүй байна.

2022 оны 01 дүгээр сарын 29-ны байдлаар зээлийн эргэн төлөлтөөр төгрөг сум хөгжүүлэх сангийн дансанд эргэн төлөгдсөн байна.

Эргэн төлөлт тогтмол хийж буй зээлдэгч

- 2019 онд зээл авсан - С.Эрдэнэбат, Ц.Мөнхцогт, Ю.Сэсээрдорж
- 2020 онд зээл авсан - Б.Цэрэнхүү, Ч.Цогзолмаа, А.Отгонхүү
- 2021 онд зээл авсан- Б.Дэнсмаа, А.Сарантуяа, Г.Нямдорж, Э.Мижиддорж, З.Дорж,

Эргэн төлөлт хийхгүй байгаа 5 зээлдэгчид:

- 2019 онд зээл авсан - Б.Сэрчмаа, Л.Мөнхнаст,
- 2020 онд зээл авсан- Б.Баатар, Э.Эрдэнэтуяа, Т.Чулуун

Сум хөгжүүлэх сан нь “Хоршоо хөгжүүлэх сан” болж өөрчлөгдөж байгаатай холбоотойгоор 2022 оны 01 сарын 01-ны өдрөөс эхлэн хэрэгжиж эхлэх журмыг талаарх мэдээллийг иргэдэд тогтмол хүргэн ажиллаж байна

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Нийгмийн бодлогын чиглэлээр:

Хүүхэд хамгааллын асуудлаар Баян багийн 1 гэр бүлтэй уулзаж холбогдох зөвлөгөө зөвлөмжийг хүргэж ажилласан.

Цар тахлын онцгой байдлын үед хүүхэд хамгааллын салбар дундын бүлгийн бэлэн байдал, хариу арга хэмжээний тайланг Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэгээс хүлээн авч нэгтгэн аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар хүргүүлсэн.

“Алдарт эхийн 1, 2 дугаар одонгийн болзол хангасан эхчүүдийн материалыг хүлээн авч байна. Одоогийн байдлаар 9 эхийн материалыг хүлээн аваад байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт:

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

1.Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн үлдэгдлийг баталгаажуулж байгаа.

2: Өдрийн үйлчилгээнд 2022оны 2сарын 23-с эхлэн 10 ахмад хамрагдаж байгаа.

Нийгмийн халамжийн чиглэлээр:

1. Жирэмсэн эх буюу 2219 дээр 2 иргэн хүлээн авч праграммд бүртгүүлсэн.
2. Цалинтай эхэд 2 иргэн бүртгэсэн.
3. Монгол банкны КАМ-н шалгуур хангаагүй 8 хүүхдийн дансыг ХААН БАНК, Төрийн банкаар засуулсан.
4. Хүүхдийн мөнгөний хүсэлт гаргаагүй 87 хүүхдийн хүсэлтийг илгээсэн.
5. Хүнсний талонд хамрагдаж байгаа 13 өрхийн 7 иргэн нийтийн цэвэрлэгээнд гарч ногоон байгууламжийн хогийг цэвэрлэсэн.

Ахмадын рашаан сувилалын 1 хөнгөлөлт, Хиймэл шүдний 3, түлээ нүүрсний 1 хөнгөлөлт шивж баталгаажуулсан. Төрийн харъяалалтай 246 ахмад настны сар шинийн хүндэтгэлийн 10000 төгрөгийг данс утастай нь шивсэн. Хураас зогсоон 1 иргэнийг сэргээсэн.

Нийгмийн даатгалын чиглэлээр:

Нийгмийн даатгалын шимтгэлд нийт 112183.9 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлээ.

Үүнээс:

- Ажил олгогчоос шимтгэлд -97065,8 мян төг
- Сайн дурын даатгалын шимтгэл- 10773,0 мян төг
- ЭМДаатгалын шимтгэлд- 4345,1 мян төг орлоо.

Хэлтсээс 200000,0 мян төгрөгийн санхүүжилт авч 461 тэтгэвэр авагчдад 395260,4 мян төгрөгийн тэтгэвэрийг олголоо.

СДДаатгалд 85 даатгуулагчидтай шинээр гэрээ байгуулан 10773,0 мян төгрөгийн шимтгэл, Эрүүл мэндийн даатгалд 68 даатгуулагчийг даатгаж 4345,1 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлсэн.

Шинээр өндөр насны тэтгэвэр -3, тахир дутуугийн тэтгэвэр-0, тэжээгчээ алдсаны тэтгэвэр -0 нийт 3 тэтгэврийг тогтоож, 4 тэтгэвэр авагчийн тэтгэврийг өөрчлөн тогтоон олгоод байна.

Улсын төсвөөс 0 сая төгрөгийг тэтгэмжийн санхүүжилт оршуулгын тэтгэмж 3 тэтгэвэр авагчдад 3000.0 мян төгрөг, жирэмсэн амаржсаны тэтгэмжинд 1 даатгуулагчдад 2484,3 мян, Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 2 даатгуулагчдад 147,0 мян төгрөгийн тэтгэмжийг тус тус олголоо.

2021 оны харилцахын-4, тооцооны хуудас тайлан-2, хөнгөлөлт чөлөөлөлтийн тайлан-1, малчны зөвлөлийн тогтоол баримтууд -1 зогсоогдсон 27 тэтгэврийн хувийн хэргийг архивлан нийгмийн даатгалын хэлтэст хүлээлгэн өгөв.

Тус хугацаанд тэтгэвэр тогтоолгох өргөдөл-3, т Банк солих-2, тэтгэмж-5, ажилгүйдлын тэтгэмж-0, малчин малчнаар ажилласан жил тогтоолгох- 0 нийт 10 өргөдлийг хүлээн авч бүрэн барагдуулж, 199 иргэнд нийгмийн даатгалын үйлчилгээг хүргээд байна.

Нийгмийн даатгалын хэлтсээс 1 сарын 9-12 өдрүүдэд зохион байгуулсан сургалтанд амжилттай оролцож, 2021 оны тайланг нийгмийн даатгалын хэлтэст хүлээлгэн өглөө.

Тэтгэвэр авагчийн 460 тэтгэврийн хувийн хэргийг тоолж бүртгэлийг шинэчилсэн.

Ерөнхий боловсролын сургууль :

- Хичээл сургалтын үйл ажиллагаагаа хэвийн явуулах, цаашид гарч болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор сумын ЭМТ-тэй хамтран 02 дугаар сарын 12-14 өдрүүдэд бүх багш, ажилчид, суралцагчдыг шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгууллаа. Мөн дотуур байрын сурагчдыг хүлээн авахдаа шинжилгээнд бүрэн хамруулсан.

- 2021 оны ажлаа зөв оновчтой төлөвлөн амжилттай хэрэгжүүлж Боловсролын газрын тоон болон чанарын үнэлгээгээр Ерөнхий боловсролын сургуулиудаас ТЭРГҮҮН байр эзэллээ.
- 02 дугаар сарын 14-нөөс хичээл сургалт танхимаар эхлэх болсонтой холбогдуулан бүх анги танхим өрөө тасалгаа, дотуур байрын тасгуудад ариутгал халдваргүйтлийг бүрэн хийсэн.
- Соёлын төвөөс зохион байгуулж буй бүжгийн дугуйланд 02 дугаар 22-ны өдрөөс 1-9 дүгээр ангийн нийт 68 хамрагдаж байна.
- “Цагаан сарыг гэр гэртээ тэмдэглэцгээе”, “Гэртээ зочин урихгүй, айлаар зочлохгүй байя”, “Хүүхдийг аюулгүй тээвэрлэе”, “Гэр гэртээ байцгаая”, “Хүүхэд хамгаалал энгийнээс эхэлнэ”, “Хүүхэдтэйгээ хамт ном уншъя”, “Гарахдаа дулаан хувцаслаж яваарай”, “Ханиад томуугаас сэргийлцгээе”, “Амны хаалтаа зөв зүүцгээе”, “Өвлийн улиралд малгайгүй явснаас үүсэх эрсдлүүд”, “Хүүхдийнхээ цүнхэнд амны хаалт, гар ариутгагч, нойтон сальфетка хийж явуулаарай” зэрэг анхааруулга санамжуудыг анги удирдсан багш нар сургуулийн нээлттэй группэд байршуулсан.
- 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн хичээл сургалтын үйл ажиллагаа 100 хувь танхимаар явагдаж байна.
- Үйлчилгээний ажилчдад нэг ээлжийн ажлын хувцас авч өгөв. Төсвөөс нийт 820,000 (найман зуун хоин мянга) төгрөг зарцуулсан.
- Сургуулийн нийгмийн ажилтан Т.Вера 2021 онд Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, хамтарсан багийн үйлчилгээг холбогдох журмын дагуу шуурхай үзүүлж, хуулиар хүлээсэн үүргээ амжилттай биелүүлж шилдэг нийгмийн ажилтнаар шалгарав.
- Анги удирдсан багш нар өдөр бүр хүүхдээ хүлээн авахдаа QR код уншуулж, халууныг үзэж тэмдэглэл хөтөлж байна.
- 02 дугаар сарын 14-ний өдрөөс дотуур байранд нийт 67 сурагч амьдарч байна.

Хүүхдийн цэцэрлэг:

- Аймгийн Боловсролын газрын тоон болон чанарын үнэлгээгээр 2021 оны ажлаараа 2-р байр эзэллээ.
- 2-р сарын 14-нд танхимын сургалт эхлэхтэй холбогдуулан бүлэг зохицуулалтыг хийж одоогоор 5 бүлэгт 155 хүүхэд хүлээн авч хичээл сургалтын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

- Ковид-19 өвчний халдварлалт ихсэж байгаатай холбогдуулан байгууллагын “Тандалтын баг” өдөр бүрийн хүүхдийн ирцэнд тандалт судалгаа хийн ажиллаж байна.
- Хичээл эхлэхийн өмнө 5 бүлгийн 136 хүүхдээс түргэвчилсэн шинжилгээ, мөн бүх багш ажилчдаас түргэвчилсэн шинжилгээ авах ажлын зохион байгууллага.
- Аймгийн Боловсролын газраас зохион байгуулсан дарга, эрхлэгч, захирлуудын зөвлөгөөнд 17-18-ны өдрүүдэд эрхлэг хамрагдлаа. Мөн энэхүү зөвлөгөөний түгээн дэлгэрүүлэлтийг байгууллага дээрээ зохион байгуулсан.\
- Аймгийн аудитын газраас “санхүүгийн аудит”-д хийгдлээ.
- Долоо хоног бүрийн баасан гаригт бүх анги бүлгүүдэд их цэвэрлэгээ, болон автомаксаар халдваргүйжүүлэлтийг хийж байна.
- БМДИ-ээс зохион байгуулсан 12 цагийн багц сургалтад нийт 2 багш амжилттай хамрагдан БАТЛАМЖ-аа авлаа.
- Өдөр бүрийн ирцийн мэдээ болон шаардлагатай бүх мэдээ тайланг цаг хугацаанд нь чанартай гарган өгч байна.
- Багш, ажилчдын 50% нь вакцины 4-р тундаа хамрагдаад байна.

Эрүүл мэндийн төв:

Нэг . Эмнэлгийн тусламж үйлчилгээ

1. Хүлээн авахын угтах лавлах үйлчилгээр 259 хүн үйлчлүүлээд байна

1.2 Тусламж үйлчилгээ

1. Амбулаторын үзлэг 210
2. Урьдчилан сэргийлэх үзлэг 53
3. Идэвхитэй хяналт 11
4. Хэвтэн эмчлүүлсэн 36 үүнээс ковидоор хэвтэн эмчлүүлсэн 10 үүнээс
5. Өдрийн эмчилгээ 14
6. Алсын дуудлага- 19
7. Гэрийн дуудлага 102

Хоёр. Товлолт дархлаажуулалт

- 2,1.Товлолт дархлаажуулалтанд 0-2 насны 29 хүүхдийг хамруулсан.

Гурав. Эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээ

3. Эрүүл мэндийн даатгалын сангаас 4-н төрлийн тусламж үйлчилгээ авдаг Үүнээс 2 дугаар сарын 22-ны байдлаар:

- Өдрийн эмчилгээ 17 үйлчлүүлэгч 1.299.970 төгрөг
- Гэрийн эмчилгээ-16 үйлчлүүлэгч 700,000 төгрөг
- Сэргээн засах -0 (сэргээн засахын эмч) үгүй учир уг тусламж үйлчилгээг үзүүлэхгүй байгаа болно.

- Оношилгоо , шинжилгээ 24 үйлчлүүлэгч 247,200 төгрөгний санхүүжилтийг одоогоор хийн ажиллаж байна. Тусламж үйлчилгээг сар болгоны 31 –ээр тасалбар болгож эрүүл мэндийн даатгалын тасагт нэмэжлэхээ явуулж санхүүжилтээ авдаг.

Дөрөв.Коронавируст халдварын тандалт эмчилгээ

4.1 Коронавируст халдвар ковид -19 нийт тохиолдол 462. 2022 оны 01 дүгээр сарын 10 нд халдвар бүртгэгдэж одоогоор 94 тохиолдол бүртгэгдээд байна. Үүнээс хүүхэд 41, насанд хүрэгчид 53 байна. Давтан батлагдсан хүүхэд 3 , насанд хүрэгчид 3 байна.

4.2 Коронавируст халдвараар сумын тусгаарлан эмчлэх тасагт 1 дүгээр сард 12 үйлчлүүлэгч 2 дугаар сард 10 үйлчлүүлэгч үүнээс 1 хүүхэд, 9 насанд хүрэгчид хэвтэн эмчлүүлсэн. Одоогоор тусгаарлан эмчлэх тасагт хэвтэн эмчлүүлэгч байхгүй бүгд эдгэрч гарсан.

4.3 Гэрийн багц эмчилгээнд 1 дүгээр сарын 24 ноос 2 дугаар сарын 22 ны өдрийг хүртэл 42 үүнээс , хүүхэд 26 насанд хүрэгчид 16 байна. Гэрийн эмчилгээнд байгаа үйлчлүүлэгчийн биеийн байдлыг өдөр бүр утсаар тандаж ажиллаж байна.

4,4 Ковид -19 халдвараар эрүүл мэндийн төвийн бага эмч 1, туслах сувилагч 1 өвдөж эдгэрсэн. Давтан халдвар авсан 1 мэргэжилтэн.

4.5 Ковид-19 халдварын шинжилгээг ерөнхий боловсролын сургуулийн 429 сурагч, 43 багш ажилчид, сургуулийн өмнөх боловсролын 93 хүүхэд, 19 багш ажилчид, эрүүл мэндийн төвийн 23 эмч мэргэжилтэнгүүдээс тандалтаар 2 удаа ард иргэдээс 101 авсан. Нийт 731 шинжилгээг шүлс болон түргэвчилсэн, пгу –аар авсан.

Тав. Жирэмсний хяналт

5.1 Он гарсаар нийт хяналтанд орсон 24 жирэмсэн эх. Төрсөн эх 1.

5.2 Умайн хүзүүний эсийн шинжилгээнд 206/12 буюу 5,8%

5.3 Хөхний эрт илрүүлэгийн үзлэгт 706/67 буюу 9,4%

Зургаа. Ковидын вакцинжуулалт

6.1 Ковид -19 халдарын нэмэлт тунгийн дархлаажуулалтанд 2022 оны 1 дүгээр сарын 24 ны байдлаар 126 иргэн хамруулсан. 2 дугаарын сарын 22-ны 74 байдлаар өссөн дүнгээр 200

- 1-р тунд 35
- 2-р тунд 12
- 3-р тунд 23
- 4-р тунд 4 хүн хамрагдсан байна

Долоо. Эрт илрүүлэгийн үзлэг

7.1 Умайн хүзүүний эсийн шинжилгээнд 206/12 буюу 5,8%

7.2 Хөхний эрт илрүүлэгийн үзлэгт 706/67 буюу 9,4%

7.3 Артерийн гипертенз эрт илрүүлэгийн үзлэг- 17

7.4 Чихрийн шижингийн эрт илрүүлэгийн үзлэг-17

Найм. Сургалт сурталчилгаа

8.1 Уулбаян эрүүл мэндийн төв фэйсбүүк хаягаар коронавируст халдвар ковид -19 халдвараас сэргийлэх зөвлөмж зөвлөгөө мэдээллийг өдөр бүр байршуулж ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгож байна. Цахимаар “ Осол гэмтлээс сэргийлье” тэмдэглэлт өдрийн хүрээнд “Аюулгүй бай- Эрүүл бай” аянг өрнүүлж 11 төрлийн зөвлөгөө зөвлөмжийг байршуулж цахим хандалт 87, эмт-өөр үйлчлүүлсэн 42 иргэдэд 4-н төрлийн гарын авлага тараасан. “Архи, согтууруулах ундааны хор уршиг” 14 хоногийн аяны хүрээнд 12 төрлийн зурагт зөвлөмж зөвлөгөөг байршуулж цахим хандалт 95 байна. Нийт 224 иргэдэд цахимаар эрүүл мэндийн боловсрол олгоод байна.

Хууль, эрх зүйн чиглэлээр:

Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2022 оны Эрх зүйн төлөвлөгөөнд 9 ажил арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулсан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу ЗДТГ нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө батлуулсан.

Сумын удирдах ажилтны зөвлөгөөг 2022 оны 02 дугаар сарын 21-ны өдөр зохион байгуулж, сумын Засаг даргын 2022 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Сумын Засаг даргаас багийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээ, Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Төрийн жинхэнэ албан хаагчийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2022 оны хөтөлбөр, Төрийн албан хаагчийн сургалтын 2022 оны төлөвлөгөө хянан баталгаажууллаа.

Төрийн албаны тусгай шалгалтад 3 албан хаагч оролцож, бүгд тэнцсэн. Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн 2021 оны тайланг бүрэн гүйцэд, зөв хийж, дээд шатны албан тушаалтанд хуулийн хугацаанд хүргүүлсэн. Энэ сард гэмт хэрэг-4, зөрчил-6 тус тус бүртгэгдсэн байна.

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН: ХУУЛЬ,
ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН

Л.ДАШБАЛЖИННЯМ